

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 08 дугаар сарын 27

Тендер шалгаруулалтын нэр: **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Гэр хороололд бохир усны шугам, бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж шинээр барих /Улаанбаатар/ ажлын Багц-1 Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй төрөх эмнэлэг, ахмадын эмнэлэг, архив, ОССК-ийн барьж буй орон сууцнуудын бохирыг зайлуулах цэвэрлэх байгууламж /2000 м3/-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/XXI-38**

Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Гэр хороололд бохир усны шугам, бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж шинээр барих /Улаанбаатар/ ажлын Багц-1 Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй төрөх эмнэлэг, ахмадын эмнэлэг, архив, ОССК-ийн барьж буй орон сууцнуудын бохирыг зайлуулах цэвэрлэх байгууламж /2000 м3 хоног/-ийн ажил-ыг гүйцэтгэх тухай** битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **200,000 (хоёр зуун мянга)** төгрөгийг тушаан худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-с доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2010, 2011, 2012 он.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд 1 тэрбум төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: “Тийм”, Аж ахуйн нэгжийн (туслан гүйцэтгэгч, түншлэл) тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн нотариатиар баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ.

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

1.3.2. Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг.

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

2.1.2. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил,

2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

2.2.3. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт,

Түншлэл болон туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх ажил үүргийн дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **30,000,000 (гучин сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 15:00 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 15 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхтэй**.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцно**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 80/1.
Нэг цэгийн үйлчилгээ. Утас: 70125060, 70111090.
www.e-procurement.mn www.e-tender.mn**